



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/12/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Н.Батжаргал

Утас: 99432788 Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## НЭГ.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2024.07.07 № 1/110  
танай 2024.01.13 -ны № 05 -т

ХОВД АЗЗА ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Н.БАТЦАГААН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Ховд АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн засаг даргын тамгын газартай байгуулсан гэрээний дагуу Ховд нисэх буудлаас Номингийн уулзвар хүртэлх 5.3 км замд сларри сийл технологиор хийх зам засварын ажлыг дуусгаж хүлээлгэн өгөөгүй байна. Үүнтэй холбоотой гэрээний өглөгийг цэвэр дүнгээр 410.8 сая төгрөгөөр санхүүгийн тайланд тусгажээ.

### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Ховд АЗЗА ТӨХК нь тайлант онд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд батлуулсны дагуу 9 багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 8 багц ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

**ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан. (ТӨГРӨГӨӨР)**

Үзүүлэлтийн нэр	Үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1.ХӨРӨНГӨ</b>	0.00	<b>0.00</b>
<b>1.1.Эргэлтийн хөрөнгө</b>	0.00	<b>0.00</b>
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	315,226,613.83	388,045,140.97
1.1.2. Дансны авлага	111,102,942.00	52,386,252.96
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	10,728,937.69	5,210,061.54
1.1.4. Бусад авлага	17,764,422.64	34,893,758.66
1.1.5.Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6.Бараа материал	273,309,899.66	820,166,269.05
1.1.7. Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	0.00	8,818,181.82
1.1.8. Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	36,500,000.00	36,500,000.00
1.1.10	0.00	0.00
<b>1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>764,632,815.82</b>	<b>1,346,019,665.00</b>
<b>1.2. Эргэлтийн бус хөрөнгө</b>	0.00	0.00
1.2.1 Үндсэн хөрөнгө	1,316,059,240.29	1,244,016,294.31
1.2.2 Биет бус хөрөнгө	230,284,000.00	229,444,000.00
1.2.3 Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5 Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6 Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8 Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
<b>1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,546,343,240.29</b>	<b>1,473,460,294.31</b>
<b>1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,310,976,056.11</b>	<b>2,819,479,959.31</b>
<b>2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	0.00	
<b>2.1 Өр төлбөр</b>	0.00	<b>0.00</b>
<b>2.1.1 Богино хугацаат өр төлбөр</b>	0.00	<b>0.00</b>
2.1.1.1 Дансны өглөг	0.00	82,080,000.00
2.1.1.2 Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3 Татварын өр	100,540.43	5,498,858.77
2.1.1.4 НДШ-ийн өр	0.00	0.00
2.1.1.5 Банкны богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6 Хүүгийн өглөг	0.00	0.00
2.1.1.7 Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	0.00	410,853,054.70
2.1.1.9 Нөөц өр төлбөр	0.00	0.00
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.11 Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөд хам	0.00	0.00
<b>2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>100,540.43</b>	<b>498,431,913.47</b>
2.1.2 Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1 Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.2 Нөөц өр төлбөр	0.00	0.00
2.1.2.3 Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр	385,901,585.00	385,901,585.00
2.1.2.5 Зээл	0.00	0.00
<b>2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>385,901,585.00</b>	<b>385,901,585.00</b>
<b>2.2 Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>386,002,125.43</b>	<b>884,333,498.47</b>
2.3 Эздийн өмч	78,052,800.00	78,052,800.00
2.3.1 Төрийн	78,052,800.00	78,052,800.00
2.3.2 Хувийн	0.00	0.00
2.3.3 Хувьцаат	0.00	0.00

2.3.4 Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5 Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	77,664,398.45	77,664,398.45
2.3.7 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	1,585,552,939.76	1,585,552,939.76
2.3.9 Хуримтлагдсан ашиг	183,703,792.47	193,876,322.63
2.3.10	0.00	0.00
2.3.11 Эздийн өмчийн дүн	<b>1,924,973,930.68</b>	1,935,146,460.84
<b>2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,310,976,056.11</b>	<b>2,819,479,959.31</b>

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан. (ТӨГРӨГӨӨР)**

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
<b>1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)</b>	<b>1,622,097,210.45</b>	<b>3,690,302,051.67</b>
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,482,854,114.14	3,429,512,342.59
<b>3. Нийт ашиг (алдагдал)</b>	<b>139,243,096.31</b>	<b>260,789,709.08</b>
4. Түрээсийн орлого	0.00	0.00
5. Хүүгийн орлого	0.00	2,199,523.39
6. Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7. Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8. Бусад орлого	128,406,955.81	66,948,501.27
9. Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10. Ерөнхий ба удирдлагын зардал	230,737,236.09	277,768,866.92
11. Санхүүгийн зардал	0.00	0.00
12. Бусад зардал	34,690,459.00	40,062,965.04
13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	2,090,909.09
15. Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16. Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17. Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
<b>18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>2,222,357.03</b>	<b>14,196,810.87</b>
19. Орлогын татварын зардал	1,032,880.00	4,024,280.71
<b>20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>1,189,477.03</b>	<b>10,172,530.16</b>
<b>21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагд)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>1,189,477.03</b>	<b>10,172,530.16</b>
<b>23. Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
Бусад олз (гарз)	0.00	0.00
<b>24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>1,189,477.03</b>	<b>10,172,530.16</b>
<b>25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан. (ТӨГРӨГӨӨР)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	78,052,800	81,102,698	1,585,552,940	173,176,064	1,917,884,502
2	НБББӨНАЗ					
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				1,189,477	1,189,477
5	Бусад дэлгэрэнгүй орлого				8,599,951	8,599,951
6	Өмчид гарсан өөрчлөлт			-		-
7	Зарласан ногдол ашиг				(2,700,000)	(2,700,000)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(3,438,300)		3,438,300	-
1	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	78,052,800	77,664,398	1,585,552,940	183,703,792	1,924,973,931
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				10,172,530	10,172,530
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт		-		-	-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2024 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	78,052,800	77,664,398	1,585,552,940	193,876,323	1,935,146,461

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан. (ТӨГРӨГӨӨР)

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн	Тайлант хугацаа
<b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1 Мөнгөн орлогын дүн</b>	<b>1,797,278,961.33</b>	<b>4,621,036,790.00</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,759,996,062.00	4,473,897,231.00
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	37,282,899.33	147,139,559.00
<b>1.2 Мөнгөн зарлагын дүн</b>	<b>1,877,653,492.40</b>	<b>4,498,497,786.25</b>
Ажиллагчдад төлсөн	310,916,800.95	517,457,395.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	125,506,049.00	196,791,110.53
Бараа материал худалдан авахад төлсөн	529,586,850.27	1,761,644,541.17
Ашиглалтын зардал төлсөн	5,800,029.80	6,187,991.61
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	512,710,479.91	1,118,632,790.00
Хүүгийн төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	140,929,720.05	209,837,775.58
Даатгалын төлбөрт төлсөн	6,275,751.00	7,122,103.00
Бусад мөнгөн зарлага	245,927,811.42	680,824,079.36
<b>1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(80,374,531.07)</b>	<b>122,539,003.75</b>
<b>2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	<b>4,499,523.39</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	2,300,000.00
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүгийн орлого		2,199,523.39
Хүлээн авсан ногдол ашиг		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>68,965,000.00</b>	<b>54,220,000.00</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	68,965,000.00	54,220,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(68,965,000.00)</b>	<b>(49,720,476.61)</b>
<b>3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>		-
Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хүү ба урамшууллын орлого		-
Төрөл бүрийн хандив		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>2,700,000.00</b>	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг	2,700,000.00	-
Бусад		
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(2,700,000.00)</b>	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(152,039,531.07)	72,818,527.14
<b>Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>467,266,144.90</b>	<b>315,226,613.83</b>
<b>Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>315,226,613.83</b>	<b>388,045,140.97</b>

## 2.5 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Д.д	Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 он		Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувиар (2023 гүй/2023 төл)	Дүнгээр (2023гүй-2023төл)
А	Б	В	1	2	3	6	7
1	Нийт орлого	Мян.төг	1,750,504.1	4,014,995.8	3,761,540.9	93.7	(253,454.9)
	Үүнээс: Улсын чанартай АЗЗА	мян.төг	1,167,227.2	3,516,626.3	3,328,028.0	94.6	(188,598.3)
	Бусад	мян.төг	583,276.9	498,369.5	433,512.9	87.0	(64,856.6)
2	Нийт зардал	мян.төг	1,748,281.7	3,945,829.3	3,747,344.1	95.0	(198,485.2)
	Үйл ажиллагааны зардалд	мян.төг	230,737.2	299,218.8	277,768.8	92.8	(21,450.0)
3	Татварын өмнөх ашиг	мян.төг	2,222.4	69,166.5	14,196.8	20.5	(54,969.7)
4	Цэвэр ашиг/ алдагдал/	мян.төг	1,189.5	62,249.8	10,172.5	16.3	(52,077.3)
5	Төсвийн төлбөрт	мян.төг	260,614.6	523,726.1	408,663.3	78.0	(115,062.8)
	а/Орлогын татварт	мян.төг	1,032.9	6,916.7	4,024.3	58.2	(2,892.4)
	б/НӨАТ	мян.төг	89,668.0	240,899.7	134,745.3	55.9	(106,154.4)
	в/НДШ	мян.төг	125,506.0	199,530.1	196,791.1	98.6	(2,739.0)
	г/ХАОТатварт	мян.төг	39,296.8	53,171.7	59,913.8	112.7	6,742.1
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татварт	мян.төг	1,058.1	1,500.0	1,142.0	76.1	(358.0)
	е/АМНАТ	мян.төг	1,001.4	15,825.5	8,004.8	50.6	(7,820.7)
	ё/Ус ашигласны төлбөр	мян.төг	357.9	1,000.0	368.2	36.8	(631.8)
	ж/Газрын төлбөр	мян.төг	819.6	918.7	1,399.6	152.3	480.9
	з/Тээврийн хэрэгслийн татварт	мян.төг	1,746.1	1,970.0	1,690.7	85.8	(279.3)
и/Бусад татварт	мян.төг	127.8	1,993.7	583.5	29.3	(1,410.2)	
6	Төрийн өмчийн ноогдол ашиг/2023 оныг тооцсон түвшин/	мян.төг	2,700.0	1,992.4	1,525.9	76.6	(466.5)
7	Нийт авлага	мян.төг	139,596.3	252,307.3	92,490.0	36.7	(159,817.3)
8	Нийт өглөг	мян.төг	386,002.1	566,221.4	884,333.5	156.2	318,112.1
	Үүнээс. 8.1 богино хугацаат	мян.төг	100.5	180,319.8	498,431.9	276.4	318,112.1
	8.2 Урт хугацаат өр төлбөр		385,901.6	385,901.6	385,901.6	100.0	-
9	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.999	0.983	0.996	101.4	0.0
10	Хөрөнгө оруулалт	мян.төг	68,965.0	191,800.0	54,220.0	28.3	(137,580.0)
11	Ажиллагсдын тоо	хүн	34	44	<b>44</b>	100.0	-
12	Цалингийн сан		483,365.6	767,423.4	774,695.3	100.9	7,271.9
13	<b>Нэг ажилтны дундаж цалин</b>	мян.төг	964.90	1,413.40	1,427.17	101.0	13.8

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 29,765.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч баталгаажуулав.

Залруулагдаагүй нийт 29,765.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 29,765.9 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрснээс алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

### 3.1 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.1.1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажиллагсадтай хийх тооцооны авлага дансыг хянан үзэхэд сарын үндсэн цалингаас илүү хэмжээний цалингийн урьдчилгаа олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажиллагсадтай хийх тооцооны авлага үүссэн ажилчдаас хуваарь гарган авлагыг төлүүлэх, цалингийн урьдчилгааг олон сараар өндөр дүнгээр олгохгүй байх.

#### 3.1.2. Цалингийн тооцоололтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн тооцооллыг хянан үзэхэд ажилчдад олгосон хоолны мөнгөнөөс эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасаагүй нийт дүнгээс татвар тооцож суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан аргачлалын дагуу татварыг тооцох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Ховд АЗЗА ТӨХК	Ажиллагсадтай хийх тооцооны авлага дансыг хянан үзэхэд сарын үндсэн цалингаас илүү хэмжээний цалингийн урьдчилгаа олгосон	1	29,765.9					1	29,765.9		
	Цалингийн тооцооллыг хянан үзэхэд ажилчдад олгосон хоолны мөнгөнөөс эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасаагүй нийт дүнгээс татвар тооцож суутгасан	1	0						1	0	
<b>ДҮН</b>		<b>2</b>	<b>29,765.9</b>			-	-	<b>2</b>	<b>29,765.9</b>		

### Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

5.1 аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
<b>НИЙТ</b>		<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			